



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ТББ-ИЙН СУДАЛГААНЫ БАГ

“МОНГОЛЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ХӨГЖЛИЙН ХОЛБОО” ТББ

“МЭЗОХХ” ТББ | Хаяг: Art house, 501 тоот, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Монгол улс
Утас: 98119921, Цахим хаяг: lxamaa@gmail.com

Судалгааны тайланг боловсруулсан

Багийн ахлагч:

Б.Лхамсүрэн

"Монголын эрх зүйн орчны хөгжлийн холбоо ТББ"-ийн гүйцэтгэх захирал

Багийн гишүүд:

Г.Оргилмаа

"Монголын эрх зүйн орчны хөгжлийн холбоо ТББ"-ийн судлаач

Д.Аюуш

"Монголын эрх зүйн орчны хөгжлийн холбоо ТББ"-ийн судлаач

Судалгааны мэдээлэл цуглуулалтад явсан судлаачид:

- Судлаач Т.Хажидсүрэн
- Судлаач Б.Эрдэнэбилэг

АГУУЛГА

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

УДИРТГАЛ

- *Судалгааны ажлын хүрээ*
- *Судалгааны зорилго, зорилт*
- *Судалгааны мэдээлэл цуглуулах арга*
- *Судалгааны багийн зохион байгуулалт, ажил үүргийн хуваарь*
- *Судалгааны мэдээлэл боловсруулалт*

1. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

2. САЛБАРЫН МЭДЭЭЛЛИЙН ХҮРТЭЭМЖ, ИЛ ТОД БАЙДАЛ

3. САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ

4. САЛБАРЫН БОДЛОГО, ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮНЭЛГЭЭ

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

ХАВСРАЛТ

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол улсын Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ыг баталж захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүйг тодорхойлсон.

Уг тогтоолын 8 дугаар зүйлийн 58-д “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэл, үндэсний хөтөлбөр, төсөл зэрэг баримт бичгээр дамжин хэрэгжиж байгаа төрийн бодлого иргэдийн амьдралд ямар үр нөлөө үзүүлснийг эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт болон хэрэглэгчийн үнэлгээгээр үнэлнэ”, 59-д “Хэрэглэгчийн үнэлгээг төрийн бодлогын хэрэгжилт, төрийн байгууллагуудаас иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн насанд хүрсэн иргэдийн 3-5 хүртэлх хувийг эсхүл аж ахуйн нэгжүүдийг хамруулан явуулсан санал асуулгын дүнг үндэслэн гаргах бөгөөд уг үнэлгээг шууд хэрэглэнэ” түүнчлэн 60-д “Хэрэглэгчийн үнэлгээг судалгаа, хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр ажилладаг мэргэжлийн болон төрийн бус байгууллагаас ажлын туршлага, хүний нөөцийн хүчин чадал зэргийг харгалзан сонгон шалгаруулж хийлгэнэ.

Тэдгээр байгууллагыг сонгох ажиллагааг тухайн үнэлгээ хийлгэх байгууллага зохион байгуулна” гэж заасны дагуу яамдаас хэрэгжүүлсэн зорилтуудын биелэлтийн талаар хэрэглэгчдийн үнэлгээг жил бүр хийж байхаар тусгасан.

Дээрх тогтоолын дагуу УУХҮЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээний газраас тендер сонгон шалгаруулалтад шалгарч хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хэрэгжүүлж буй бодлого, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлгээ хийж хэрэглэгчийн үнэлгээний судалгааны тайланг бэлтгэлээ.

Хэрэглэгчийн үнэлгээний судалгааны ажлыг №УУХҮЯ/201801009 тоот гэрээний хүрээнд гүйцэтгэсэн.

“Хэрэглэгчийн үнэлгээ хийх” зөвлөх үйлчилгээний судалгааг хийх цаг хугацаанд аж ахуй нэгж байгууллага, хэрэглэгчдээс санал асуулга, мэдээлэл цуглуулахад ихээхэн саад бэрхшээл (судалгаанд оролцогчдын идэвхгүй байдал, цаг хугацаа богино) тулгарч байсан ч гэрээнд заасан хугацаанд буюу Зөвлөх үйлчилгээний ажлыг хийж гүйцэтгэлээ.

УУХҮЯ-ны хувьд Хэрэглэгчийн үнэлгээг хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар анх удаа хийлгэж байгаа бөгөөд өмнөх жилүүдийн тайланг харьцуулан үзэж боломжгүй байсан болно.

Хэрэглэгчийн үнэлгээний судалгаа 2018

Товчилсон үгийн жагсаалт

- АМТХ-Ашигт малтмалын тухай хууль
- ААҮАТЗТХ-Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль
- БОНБҮТХ-Байгаль орчинд нөлөөлөх үнэлгээний тухай хууль
- БОНБҮ-Байгаль орчинд нөлөөлөх үнэлгээ
- БОЕҮ-байгаль орчны ерөнхий үнэлгээ
- БОНҮ- байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ
- ЗЗНДНТУТХ-Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай
- ОНИТХ-Орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал
- УИХ-Улсын Их Хурал
- ТЗТБ-Төрийн захиргааны төв байгууллага
- ТЗБ-Төрийн захиргааны байгууллага

УДИРТГАЛ

- Судалгааны ажлын хүрээ

Засгийн газрын дунд хугацааны төлөвлөлт, түүний хэрэгжилт нь тухайн нийгмийн хөгжилд шийдвэрлэх үүрэгтэй. Бодлого, хөтөлбөрийн гол үр дүн нь иргэдэд мэдрэгдэж, амьдрал, ахуйд нь ахиц дэвшил бий болгон, иргэдийн оролцоо, хандлагад нь эерэг нөлөө үзүүлж байх явдал юм. Түүнчлэн бодлогын хэрэгжилтийг сайжруулах гол арга зам нь хэрэгжилтэд байнгын тандалт судалгаа хийх, түүний үр дүнд суурилсан зохицуулалт, залруулга, тодруулга хийх явдал юм. Үүнийг иш үндэс болгон Засгийн газраас жил бүр бодлогын хэрэгжилтийн талаарх иргэдийн үнэлгээг хийх шийдвэр гаргасан нь нэг талаар төрийн нээлттэй байдал, иргэдийн оролцоог хангах, нөгөө талаар тэдний санал бодолд суурилсан бодлого, шинэчлэлийг хэрэгжүүлэх нэгэн алхам болж байна,

Монгол улсын Засгийн газрын 2010 оны 11 дүгээр тогтоол “Яам болон аймаг, нийслэлийн Засаг дарга, Засаг даргын тамгын газрын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журам”-ыг баталж, дээрх байгууллагуудаас тухайн жилд хэрэгжүүлсэн зорилтуудын биелэлт, үр нөлөөний талаар хэрэглэгчдийн үнэлгээг жил бүр хийж, үйл ажиллагаандаа дүгнэлт хийж ажиллаж байхаар заасан байна.

2012 оноос Засгийн газраас бодлогын төлөвлөлт, хэрэгжилтийн төвд иргэд, хэрэглэгчдийг дээдлэн үйл ажиллагаагаа нээлттэй ил тод болгох, үйлчилгээнийхээ нэр төрлийг өргөжүүлэх, иргэн бүрд хүргэх, үйлчилгээг шуурхай, чанартай болгох, тэдний оролцоонд тулгуурлах зарчмыг гол болгож байна. Бодлого, үйл ажиллагааны эцсийн үр дүнг иргэд тодорхойлдог учраас аливаа бодлогын талаарх мэдээлэл тэдэнд үнэн, бодитой, хүртээмжтэй байдал, уг бодлого, хөтөлбөрийн үйл ажиллагаа иргэдийн амьдралын чанарт гарах дэвшилтэт өөрчлөлт бий болгон, иргэдийн идэвх санаачилга, бүтээлч байдал, оролцоо, хамтын ажиллагааг хангасан байх учиртай юм.

Туршлагаас дүгнэж үзэхэд энэ нь бодлого, үйл ажиллагааны хэрэгжилтийг тодорхойлох арга, хяналт шинжилгээ үнэлгээний нэг хэрэгсэл, үр дүн, үр нөлөөг тооцох бодит шалгуур болж байна.

Хэрэглэгчийн үнэлгээний судалгаа тухайн жилд хэрэгжсэн салбарын бодлогын зорилтууд, үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх боломжийг олгодог. Эдгээр нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын үйл ажиллагааны хүрээнд 2017 он хүртэлх бодлого, үйл ажиллагааны талаарх хэрэглэгчийн үнэлгээний судалгааг хийх гол үндэслэл болсон юм.

Судалгааны зорилго, зорилт:

Уул уурхайн сайдын эрхлэх асуудлын хүрээнд 2014-2018 онд хэрэгжүүлсэн бодлого, хөтөлбөр иргэд, хэрэглэгчид, тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын үйл ажиллагаанд нөлөөлж буй байдал, салбарын үйл ажиллагаа, үйлчилгээний чанар, хүртээмж, ил тод байдлыг үнэлүүлэх, мөн салбарын тулгамдсан асуудлыг тодорхойлох;

Дээрх зорилгын хүрээнд дараах дэд зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын мэдээллийн ил тод байдлын үнэлгээ (салбарын үйл ажиллагааны болон үйлчилгээний талаарх мэдээллийн хүртээмж);

2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын 2018 он хүртэлх бодлого, хөтөлбөрүүдийн үйл ажиллагааны үр дүн, хэрэгжилтийн үнэлгээ;
3. Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын үйл ажиллагаа, үйлчилгээний талаарх хэрэглэгчийн сэтгэл ханамж;
4. Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт тулгамдаж буй асуудал
5. Хууль, эрх зүйн орчны зохицуулалтын өнөөгийн байдлыг үнэлүүлэх гэсэн үндсэн таван зорилтыг тавьж судалгааны ажлыг гүйцэтгэн тайлан, үр дүнг гаргалаа.

Судалгааны мэдээлэл цуглуулах арга:

Үр дүнгийн үнэлгээ нь “Бид амжилт эсвэл үр дүн гарсан эсэхийг хэрхэн мэдэх вэ? Бид хүлээгдэж буй үр дагаварт хүрэхэд зөв чиглэлд явж байна уу?”¹ гэсэн асуултад хариулахад чиглэдэг Засгийн газар, яам, агентлаг, орон нутгийн удирдах байгууллагуудын аль алинд үнэлгээний судалгаа хийх үнэлгээний шалгуур үзүүлэлтийг боловсруулдаг онцлогтой. Тодруулбал, аргачлалын хувьд "... орц, үйл ажиллагаа, гарц, үр дагавар, зорилттой холбоотой бүх үйл явцад хяналт- шинжилгээ хийх... Амжилтад хүрсэн болон сайжруулах шаардлагатай хэсгүүдийн талаарх шинэчилсэн мэдээллээр хангах үүднээс тогтолцооны бүх түвшний ахиц өөрчлөлтөд хяналт-шинжилгээ хийх хэрэгтэй болдог" бөгөөд үйл ажиллагааны өөрчлөлтөд нийцүүлэн шинэ шалгуур үзүүлэлт боловсруулах, эсвэл тогтсон бүтэц, үйл ажиллагааны хүрээнд үнэлгээ хийх бол өмнөх шалгуур үзүүлэлтийг ашиглаж үнэлгээг тооцдог.

Өмнө хийсэн үнэлгээний судалгааны үр дүнг ашиглах нь цаг хугацааны хувьд боломж олгохоос гадна өмнөх жилүүдтэй үр дүнгээ харьцуулж тооцох, ахиц дэвшил гарсан эсэхийг нягтлах боломж олгодгоороо давуу талтай. Иймээс бид 2013-2014 оны үнэлгээний судалгааны хоёр төрлийн асуулгыг ашигласан. Ингэхдээ үнэлгээний асуулгад:

1. УУХҮЯ-аас 2014-2018 онд гаргасан бодлого, хөтөлбөрийн талаарх мэдээллийг шинээр оруулж өгсөн.
2. Яамны мэргэжилтнүүдийн саналыг авч, анкетын асуултад оруулж судалгааны мэдээлэл цуглуулах хэрэглэгдэхүүнийг эцэслэн батлуулсан болно.

Тоон аргаас гадна хурал зөвлөгөөний материал, салбарын ажлын тайлан явц холбогдох бусад эх сурвалжуудад шинжилгээ хийх замаар ажлын үр дүнг үнэллээ.

Судалгааны багийн ажил үүргийн хуваарь болон зохион байгуулалт:


Хүснэгт №1. Ажил үүргийн хуваарь

Нэр	Албан тушаал	Ажлын туршлага	Хариуцах ажил
Д.Аюуш	Зөвлөх үйлчилгээни	Социологийн болох хууль	Захиалагч байгууллага, удирдлагуудтай харилцаа холбоо тогтоон, судалгааны багийг төлөөлөн ажиллах

¹Жоди Золл Кусес, Рейс С.Рист. үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог хөгжүүлэх 10 10 алхам. Орч: ДСолонго. Дэлхийн банк. Вашингтон хот. 2004: 84.


	й багийн судлаач	зүйн судалгаа шинжилгээ	- Судалгааны мэдээлэл цуглуулах болон мэдээллийн бааз үүсгэх, боловсруулалт хийх ажлын гүйцэтгэлд хяналт тавих, гарч болзошгүй алдаа, дутагдлыг сэргийлэх, чиглүүлэх - Судалгааны багийн ажилд шаардагдах төсвийн төлөвлөлт, зарцуулалтын үйл ажиллагааг удирдлагаар хангах
Б.Лхамсүрэн	Зөвлөх үйлчилгээний багийн ахлагч	Судалгаа шинжилгээ, хуулийн төсөл боловсруулах, өмгөөллийн үйл ажиллагаа	- Судалгааны багийн ажил үүргийг нэгдсэн удирдлагаар хангах - Захиалагч байгууллага, удирдлагуудтай харилцаа холбоо тогтоон, судалгааны багийг төлөөлөн ажиллах - Судалгааны мэдээлэл цуглуулах болон мэдээллийн бааз үүсгэх, боловсруулалт хийх ажлын гүйцэтгэлд хяналт тавих, гарч болзошгүй алдаа, дутагдлыг сэргийлэх, чиглүүлэх - Судалгааны багийн ажилд шаардагдах төсвийн төлөвлөлт, зарцуулалтын үйл ажиллагааг удирдлагаар хангах
Г.Оргилмаа	Зөвлөх үйлчилгээний багийн судлаач	Судалгаа шинжилгээ, хуулийн төсөл боловсруулах, өмгөөллийн үйл ажиллагаа	- Захиалагч байгууллага, удирдлагуудтай харилцаа холбоо тогтоон, судалгааны багийг төлөөлөн ажиллах - Судалгааны мэдээлэл цуглуулах болон мэдээллийн бааз үүсгэх, боловсруулалт хийх ажлын гүйцэтгэлд хяналт тавих, гарч болзошгүй алдаа, дутагдлыг сэргийлэх, чиглүүлэх - Судалгааны багийн ажилд шаардагдах төсвийн төлөвлөлт, зарцуулалтын үйл ажиллагааг удирдлагаар хангах

Бүдүүвч №2. Мэдээлэл цуглуулах ажлын удирдлага, зохион байгуулалт, түүвэрлэлт





Б. МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЭХ БАГ



Хэрэглэгчийн үнэлгээний судалгааг гүйцэтгэхэд багийн ахлагч, багийн гишүүн 2 нийт 3 гишүүнтэй. Харин мэдээлэл цуглуулалтад Улаанбаатар хотод 5 судлаачтай, Мэдээллийн дата бааз үүсгэх оператор 2, үүсгэсэн дата баазыг хянах, түүнд дүн шинжилгээ хийх 1 хүн нийт 3 ажилтан байна.

Судалгааны мэдээлэл боловсруулалт:

Судалгааны зорилго, мэдээлэл цуглуулахаар сонгосон аргуудтай уялдан мэдээлэл дэх шинж тэмдгийн утгуудыг тоон болон тоон бус шинжээр илэрхийлэгдэх байдлаар нь ангилан дүн шинжилгээ хийлээ. Үүнд:

А. Анкетын аргаар цуглуулсан тоон мэдээлэлд нийгмийн судалгааны мэдээллийг боловсруулдаг SPSS 20 программаар математик, статистик шинжилгээ хийсэн.

Б. Тоон бус утгаар илэрхийлэгдэх мэдээлэлд (баримт бичгийн судалгаа) контент анализ, логик шинжилгээ хийх байдлаар чанарын боловсруулалт хийлээ.

I. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үйл ажиллагаанд хийсэн хэрэглэгчийн үнэлгээнд төрийн байгууллагад ажилладаг 162, хувийн хэвшилд ажилдаг 342, их, дээд сургуульд ажилладаг 72 **нийт 576 хүн** хамрагдаж байна.


Хүснэгт №1.1. Судалгаанд хамрагдсан түүвэр

№	Утга	Тоололт	Хувь
1	Төрийн байгууллага	162	28.1
2	Хувийн хэвшил	342	59.4
3	Их, дээд сургууль	72	12.5
Нийт		576	100

Төрийн байгууллагуудын хувьд: ЗТЯ, БОАЖЯ, БХБЯ зэрэг яамдууд, ГЗБГЗЗГ, ГТЛ зэрэг агентлагууд, Эрдэнэт үйлдвэр, Эрдэнэс монгол, Дарханы төмөрлөгийн үйлдвэр, Оюу толгой зэрэг төрийн өмчит үйлдвэрүүд хамрагдсан бол Их, дээд сургуулиудаас МУИС, ШУТИС зэрэг сургуулийн багш нар хамрагдсан байна.²

Түүврийн хүн ам зүйн ерөнхий харьцаа буюу нас, хүйс, боловсрол, ажил эрхлэлтийн байдлыг тооцсон бөгөөд энэ дагуу судалгааны үндсэн мэдээллийг цуглуулахдаа гурван шатлалтай, санамсаргүй түүврийн аргыг ашигласан. Тодруулбал: түүврийн эхний шатанд дүүргийг сонгож, хоёрдугаар шатанд хороог, гуравдугаар шатанд судалгаанд оролцогч респондентийг санамсаргүйгээр сонгож анкетын асуулгын дагуу нүүр тулсан ярилцлага хийж анхдагч мэдээллийг цуглуулсан. Түүврийн нарийвчлалыг ханган ажиллахаас гадна судлаачийн ур чадвар, туршлагаас хамаарч судалгааны үр дүнд хөндлөнгийн нөлөөлөл орох магадлал өндөр байдаг тул мэдээлэл цуглуулагчдын дунд тусгайлан сургалт зохион байгууллаа. Өөрөөр хэлбэл, зохих шаардлага, нөхцөлийг хангасны эцэст судалгааны анхдагч мэдээллийг цуглуулж эхэлсэн.


График №1.1. Судалгаанд оролцогчдын нас болон хүйс



Судалгаанд оролцогчдын насны бүтцийг харвал 10 хувь нь 24 хүртэлх насныхан, 40 хувь нь 25-34 насныхан, 33 хувь нь 35-44 насныхан, 10 хувь нь 45-54 насныхан, 7 хувь нь 55-аас дээш настай иргэд байна. Тэдний 64 хувь нь эрэгтэй, 36 хувь нь эмэгтэйчүүд байна.


График №1.2. Судалгаанд оролцогчдын боловсролын байдал

² Хувийн хэвшлийн компаниудыг маш олон учир дэлгэрэнгүй дурдсангүй.



Судалгаанд оролцогчдын 90 хувь нь дээд боловсролтой, үлдсэн 10 хувь нь суурь, бүрэн дунд болон техникийн болон тусгай мэргэжлийн боловсрол эзэмшсэн хүмүүс байна.

График №1.3. Судалгаанд оролцогчдын ажил эрхлэлтийн байдал



Судалгаанд оролцогчдын 35 хувь нь төрийн байгууллагад, 53 хувь нь хувийн байгууллагад, 5 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 4 хувь нь төрийн бус байгууллагад, 3 хувь нь олон улсын байгууллагад тус тус ажилладаг байна.


II. САЛБАРЫН МЭДЭЭЛЛИЙН ХҮРТЭЭМЖ, ИЛ ТОД БАЙДАЛ

"Мэдээллийн ил тод байдал мэдээлэл авах эрхийн тухай" хуулийн дагуу олон нийтийн зүгээс тодорхой нөхцөл шаардлагын дагуу төрийн аль шатны албан байгууллагаас мэдээлэл хүсэх, хүлээн авах эрхийг нь баталгаажуулсан бол төрийн шат шатны албан байгууллага үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүү, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны² талаарх мэдээллийг олон нийтэд тодорхой хугацаанд мэдээлэх үүрэг хүлээсэн байдаг.

Энэ нөхцөл, шаардлагын дагуу Уул, уурхай хүнд үйлдвэрийн яамны үйл ажиллагааны талаарх мэдээллийн хүртээмж, ил тод байдлыг дараах гэсэн шалгуур үзүүлэлтэд тулгуурлан үнэллээ:


- | | |
|----------------------|---|
| <i>Нэгдүгээрт:</i> | Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааны талаарх мэдээллийг олж авч байгаа эх үүсвэрийг тодорхойлох; |
| <i>Хоёрдугаарт:</i> | Салбарын үйл ажиллагааны талаарх мэдээлэл олон нийтийн хэрэгцээ(мэдээллийн агуулга нь олон нийтийн хэрэгцээнд нийцсэн эсэх)-г хангаж буй байдал буюу мэдээллийн хүртээмж; |
| <i>Гуравдугаарт:</i> | Хэрэгцээтэй үедээ мэдээллийг авч чадаж байгаа эсэх буюу мэдээлэл түгээж буй байдал. |

График № 2.1. Хэрэглэгчдийн мэдээлэл авч буй эх сурвалж




Хэрэглэгчийн үнэлгээнд оролцсон хүмүүсийн $\frac{1}{2}$ буюу 47 хувь нь яамны үйл ажиллагааны мэдээллийг интернет орчин, цахим сайтаас нь авдаг гэсэн бол 25 хувь нь телевиз, радио, 15 хувь нь хэвлэл мэдээлэл, сонин сэтгүүл, 12 хувь нь яам, тамгын газраар дамжуулж тус тус авдаг гэж хариулжээ.

График №2.2. Мэдээллийн эх сурвалжийн үнэлгээ




Судалгаанд оролцогчид мэдээлэл авч буй эх сурвалжаа дээрх байдлаар үнэлсэн байна. Тэдний $\frac{1}{5}$ буюу 19.4 хувь нь үнэлж мэдэхгүй, $\frac{1}{3}$ буюу 29 хувь нь дунд зэрэг, 18.5 хувь нь хангалтгүй буюу бага, 16.1 хувь нь сайн, 10.5 хувь нь маш сайн гэж тус тус үнэлсэн байна.

График №2.3. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны хэрэгжүүлж байгаа ажлууд болон ил тод байдлын үнэлгээ



Судалгаанд оролцогчид тус яамны хэрэгжүүлж байгаа ажлууд болон ил тод байдлыг үнэлэхдээ 5.8 хувь нь ач холбогдолгүй, 26.1 хувь нь бага, 32 хувь нь дунд зэрэг, 13.5 сайн, 7.3 маш сайн гэж тус тус үнэлсэн бол 15.3 хувь нь хараахан үнэлж мэдэхгүй байна гэжээ.

График №2.4. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны худалдан авах үйл ажиллагаа буюу тендер шалгаруулалтын шударга явагддаг эсэхийг үнэлсэн үнэлгээ



Харин энд судалгаанд оролцогчдоос тус яамны худалдан авах ажиллагааны шударга явагддаг талаар үнэлгээний асуултад хариулсан байдлыг авч үзвэл: тэдний 9.5 хувь нь ач холбогдолгүй, 25.8 хувь нь бага, 21.5 хувь нь дунд зэрэг, 10.5 хувь нь сайн, 5.1 хувь нь маш сайн гэж тус тус үнэлсэн бол 1/3 нь буюу 27.6 хувь энэ үйл ажиллагааны талаар үнэлж мэдэхгүй байв.

III. САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ

Энэхүү ажлын хүрээнд эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем болох www.legalinfo.mn цахим сайтаас ашигт **малтмал**, **эрдэс баялаг** зэрэг түлхүүр үгээр хайлт хийхэд доорх хууль, эрх зүйн актууд олдож байна. Үүнд:

- Хууль-70³
- УИХ-н тогтоол-43
- Олон улсын гэрээ-6
- Ерөнхийлөгчийн зарлиг-1
- УИХ-аас томилогддог байгууллага, түүнтэй адилтгах албан тушаалтны шийдвэр-0
- Үндсэн хуулийн цэцийн шийдвэр -1
- Улсын дээд шүүхийн тогтоол-3
- ЗГ-ын Тогтоол-104
- Сайдын тушаал-21
- Аймаг, нийслэлийн засаг даргын захирамж-12 байна.

Ашигт малтмалын тухай, Газрын тосны тухай, Цөмийн энергийн тухай, Газрын хэвлийн тухай, Газрын тосны бүтээгдэхүүний тухай, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох журмын тухай зэрэг гол хуулиуд, 2014 оны 1-р сарын 16-ны өдөр батлагдсан Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого батлах тухай Улсын Их хурлын 18 дугаар тогтоол, 2011 оны 12-р сарын 23-ны өдөр батлагдсан Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлого батлах тухай Улсын Их Хурлын 65 дугаар тогтоол нь бодлогын бичиг баримтын голлох эх сурвалж болж байна.

Ашигт малтмалын тухай (шинэчилсэн найруулгыг) хууль Улсын Их Хурлаас 2006 оны 7 дугаар сарын 8-ны өдөр батлагдсан. Батлагдсан өдрөөс хойш нийт 28 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна. Төсвийн хүрээний мэдэгдлийн хүрээнд 2017 оны 11-р сарын 10-ны өдөр хамгийн сүүлд хэд хэдэн зарчмын шинжтэй нэмэлт өөрчлөлт орсон бөгөөд энэхүү өөрчлөлтийн талаарх хэрэглэгчдийн сэтгэгдлийг анх удаа энэхүү судалгаагаар гаргаж ирж байгаа болно.


³ Жагсаалтыг хавсралт 1-ээс үзнэ үү.

График №3.1. Эрдэс баялгийн салбарт төрөөс баримталж буй бодлогын баримт бичгүүд ард иргэдэд хэрхэн хүрч байгааг үнэлсэн үнэлгээ




Судалгаанд оролцогчид энэ салбарт төрөөс баримталж буй бодлогын баримт бичгүүдэд маш шүүмжлэлтэй хандаж байна. Тэдний 11.4 хувь нь ач холбогдолгүй, 43.4 хувь нь бага, 21.4 хувь нь дунд зэрэг, 6.8 хувь нь сайн, 6 хувь нь маш сайн гэж тус тус үнэлсэн бол 11 хувь нь энэ талаар мэдэхгүй гэжээ.

График №3.2. Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөд хэр сэтгэл ханамжтай байгаа байдлын үнэлгээ



2017 оны 11 сарын 10-ны Ашигт малтмалын тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийг судалгаанд оролцогчид дараах байдлаар үнэлсэн байна. Тэдний 10.5 хувь нь энэхүү өөрчлөлтийг ач холбогдолгүй, 25 хувь нь бага, 21.7 хувь нь дунд, 12.7 хувь нь сайн, 7.2 хувь нь маш сайн гэж үнэлсэн бол 22.8 хувь нь үнэлж мэдэхгүй гэж хариулжээ.

График №3.3. Салбарын хуулийн хэрэгжилтийг хангуулах, эрх зүйн орчныг сайжруулахын тулд Газрын хэвлийн багц хууль боловсруулах, өөрчлөлт хийх саналыг Та дэмжиж байна уу? гэсэн асуултын үнэлгээ



Судалгаанд оролцогчид салбарын эрх зүйн орчныг сайжруулахын тулд Газрын хэвлийн багц хууль боловсруулах өөрчлөлт хийх саналын талаар 11.1 хувь нь ач холбогдолгүй, 14 хувь бага, 9.6 хувь нь дунд, 19.2 хувь нь их, 25.5 хувь нь маш их хэрэгтэй гэж дүгнэжээ. Харин тэдний 20.7 хувь нь энэ талаар хараахан мэдээлэлгүй, мэдэхгүй гэж хариулжээ.

Дээрх багц хуулийн өөрчлөлтийн талаарх гаргасан судалгаанд оролцогчид дараах саналыг гаргасан байна:

- *Байгаль орчин уул уурхай яам гэж өөрчлөх нэг яам болж ажиллавал бодлого төлөвлөлт хамгаалалт сайжруулах*
- *Нээлттэй ил тод. Нээлттэй тогтолцоог бүрдүүлэх*
- *Оюу толгойн гэрээнд өөрчлөлт оруулах Монгол Улсын хүртэх хэмжээг нэмэгдүүлэх*
- *Монголын ард түмэн байгалийн баялгаасаа хувь хүртэх боломж олгох*
- *Хууль нь тодорхой. Ойлгомжтой хуулиа шударгаар мөрддөг байх*
- *Лиценз эзэмшигчдийн хариуцлагыг нэмэгдүүлэх, дамлан худалдахыг хориглох, ашиглахгүй лицензийг тодорхой хураах*
- *Орон нутгийн иргэдийг 3/4-өөс дээш саналыг үндэслэн тусгай зөвшөөрлийг олгох*
- *Өмнө хийсэн алдаатай гэрээнүүдийг засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах*
- *Монгол Улс лиценз эзэмшигчээс баялгаараа хувь эзэмших*
- *Бүх шатны иргэд аж ахуйн нэгж, байгууллагад тэгш эрхтэй, шударга ёс зүйд нийцсэн, ил тодоор байгаль орчинд ээлтэй байхаар боловсруулж хэрэгжилтэд нь хяналт тавих*
- *Хууль эрх тэгш нээлттэй үйлчлэх чухал*
- *Давхцалуудыг арилгах, амьдралд хэрэгжих боломжийг хангах*
- *Хууль зүйн орчныг тогтвортой, авлигаагүй байлгах*
- *Хэт олон өөрчлөлт тогтоолууд нь будилуулж толгой эргүүлэхээс цаашгүй байна. Маш сайн боловсруулсан хууль шаардлагатай байна*
- *Зөвшөөрлийг олгох тал дээр иргэдийн саналыг авдаг байх, Сонгон шалгаруулалтыг сайтар дэлгэрэнгүй байлгах.*


IV. САЛБАРЫН БОДЛОГО, ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮНЭЛГЭЭ

2014 оны 1-р сарын 16-ны өдөр батлагдсан Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого батлах тухай Улсын Их хурлын 18 дугаар тогтоол, 2011 оны 12-р сарын 23-ны өдөр батлагдсан Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлого батлах тухай Улсын Их Хурлын 65 дугаар тогтоол нь бодлогын голлох эх сурвалж болж байна.

2014 оны 1-р сарын 16-ны өдөр батлагдсан Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого батлах тухай Улсын Их хурлын 18 дугаар тогтоолын хувьд:


Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого нь хувийн хэвшилд түшиглэсэн, ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, ойрын болон дунд хугацаанд эдийн засгийн тэнцвэртэй олон тулгуурт бүтцийг бий болгож, үндэсний язгуур эрх ашгийг хангахад чиглэсэн, өрөнгө оруулалтын тогтвортой орчныг бүрдүүлж, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай, дэвшилтэт техник, технологи, инновацийг дэмжих замаар ашигт малтмалын хайгуул, олборлолт, боловсруулалтын чанарыг дээшлүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, олон улсын зах зээлд өрсөлдөх чадварыг бэхжүүлэх зорилготой. Энэхүү бодлогын баримт бичиг нь төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах зарчим, хөгжлийн чиглэлийг тодорхойлж, удирдлагын тогтолцоог боловсронгуй болгоход чиглэх бөгөөд тэдгээр нь эрдэс баялгийн салбарын хууль тогтоомж, дунд, урт хугацааны хөтөлбөр, дэд хөтөлбөр, төсөлд тусгагдан хэрэгжинэ.

График №4.1. Хүнд үйлдвэрийн талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичиг нь салбарын хөгжлийн төлөв, улс орны эдийн засаг, нийгмийн хөгжилд оруулах үүрэг оролцоог бүрэн тодорхойлсон гэж үзэж байна уу? гэсэн асуултын үнэлгээ.




Энэ салбарт төрөөс баримтлах бодлогын баримт бичиг нь салбарын хөгжлийн төлөв, улс орны эдийн засаг, нийгмийн хөгжилд оруулах үүрэг оролцоог бүрэн тодорхойлсон эсэхэд судалгаанд оролцогчдын 9.6 хувь нь ач холбогдолгүй, 24.3 хувь нь бага, 21.7 хувь нь дунд, 11.4 хувь нь их, 9.2 хувь нь маш их гэж үнэлсэн бол 23.9 хувь мэдэхгүй гэж хариулжээ.

График №4.2. Ашигт малтмал газрын тосны газар орон нутаг руу чиглэсэн үйл ажиллагааг Та хэрхэн үнэлэх вэ? гэсэн асуултын үнэлгээ




Судалгаанд оролцогчид ашигт малтмал газрын тосны газрын орон нутаг руу чиглэсэн үйл ажиллагааг үнэлэхдээ: 9.6 хувь бага, 33.8 хувь нь бага, 19.9 хувь нь дунд, 12.9 хувь нь их, 8.5 хувь нь маш их гэж үнэлсэн бол 15.4 хувь нь үнэлж мэдэхгүй гэжээ.

График №4.3. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлын төлөвт, үйл ажиллагааны явцад өгсөн үнэлгээ




Судалгаанд оролцогчид улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлын төлөвлөлт, үйл ажиллагааны явцыг 7.7 хувь нь ач холбогдолгүй, 28.8 хувь нь бага, 24.8 хувь нь дунд, 13.9 хувь нь их, 7.3 хувь нь маш их гэж үнэлсэн бол 17.5 хувь нь энэ талаар хэлж мэдэхгүй гэж хариулжээ.

График №4.4. Газрын тосны геологийн судалгааны ажлын төлөвлөлт, ажлын үр дүн, үйл ажиллагааг үнэлсэн үнэлгээ




Судалгаанд оролцогчид газрын тосны геологийн судалгааны ажлын төлөвлөлт, үр дүнгийн талаар 9.5 хувь нь ач холбогдолгүй, 27.3 хувь нь бага, 25.1 хувь нь дунд, 11.6 хувь нь их, 6.5 хувь нь маш их гэж үнэлсэн бол 1/5 нь энэ талаар үнэлгээ өгч мэдэхгүй гэжээ.

График №4.5. Хувийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлын төлөвлөлт, ажлын үр дүн, үйл ажиллагааг үнэлсэн үнэлгээ




Судалгаанд оролцогчид хувийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлын төлөвлөлт, ажлын үр дүнгийн талаар 6.7 хувь нь ач холбогдолгүй, 18.5 хувь нь бага, 20 хувь нь дунд, 23 хувь нь их, 12.6 хувь нь маш их гэж үнэлсэн бол 19.3 хувь нь үнэлж мэдэхгүй гэжээ.

График №4.6. Газрын тос, байгалийн хий, шатдаг занар, нүүрс зэрэг ус төрөгчдийн нэгдлийн ашигт малтмалын геологийн судалгааны ажлыг үнэлсэн үнэлгээ




Судалгаанд оролцогчид газрын тос, байгалийн хий, шатдаг занар, нүүрс зэрэг ус төрөгчдийн ашигт малтмалын геологийн судалгааны ажлын талаар 8.1 хувь нь ач холбогдолгүй, 22.3 хувь нь бага, 24.9 хувь нь дунд, 12.8 хувь нь их, 7.3 хувь нь маш их гэж үнэлсэн бол 24.5 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.

График №4.7. Төрөл бүрийн ашигт малтмалын олборлох, баяжуулан боловсруулах үйлдвэрийн талаарх стратегийн төлөвлөлт, хүрсэн үр дүнг үнэлсэн үнэлгээ




Судалгаанд оролцогчид төрөл бүрийн ашигт малтмалын олборлох, баяжуулан боловсруулах үйлдвэрийн талаарх стратегийн төлөвлөлт, хүрсэн үр дүнгийн талаар 6.9 хувь нь ач холбогдолгүй, 27.5 хувь нь бага, 27.2 хувь нь дунд, 8.7 хувь нь их, 8.7 хувь нь маш их гэж тус тус үнэлсэн бол 21 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.

График №4.8. Улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд уул уурхайн салбарын үзүүлж буй ач холбогдлыг үнэлсэн үнэлгээ




Судалгаанд оролцогчид улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд уул уурхайн салбарын үзүүлж буй ач холбогдлын талаар 5.8 хувь нь ач холбогдолгүй, 17.8 хувь нь бага, 19.6 хувь нь дунд, 23.6 хувь нь их, 22.8 хувь нь маш их гэсэн үнэлгээг өгсөн бол 10.5 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.

График №4.9. Уул уурхайн нөхөн сэргээлтийн ажлын түвшнийг үнэлсэн үнэлгээ.




Судалгаанд оролцогчид уул уурхайн нөхөн сэргээлтийн ажлын түвшнийг үнэлэхдээ: 16.2 хувь нь ач холбогдолгүй, 38.3 бага, 20.6 хувь нь дунд, 10.5 хувь нь их, 5.8 хувь нь маш их гэж үнэлсэн бол 8.7 хувь нь мэдэхгүй гэжээ.

График №4.10. Уул уурхайн салбарын үйл ажиллагааны үр дүнд ажлын байр нэмэгдсэн. Энэ нэмэгдэл нь хангалттай хэмжээнд байж чадаж байна уу? гэсэн асуултын үнэлгээ



Судалгаанд оролцогчид уул уурхайн салбарын ажлын байр нэмэгдсэн. Энэ нь хангалттай хэмжээнд байсан талаар 6 хувь нь ач холбогдолгүй, 26.7 хувь нь бага, 34.9 хувь нь дунд, 15.3 хувь нь их, 5.7 хувь нь маш их гэсэн тус тус үнэлсэн бол хувь нь үнэлж мэдэхгүй гэжээ.

График №4.11. Уул уурхайн компаниудын хөдөө, орон нутаг дахь хөрөнгө оруулалтыг Та хэрхэн үнэлэх вэ?



Судалгаанд оролцогчид уул уурхайн компаниудын хөдөө, орон нутаг дахь хөрөнгө оруулалтын талаар 8.4 хувь нь ач холбогдолгүй, 32.7 хувь нь бага, 23.6 хувь нь дунд, 14.5 хувь нь их, 9.1 хувь нь маш их гэж тус тус үнэлсэн бол 11.6 хувь нь үнэлж мэдэхгүй гэжээ.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үйл ажиллагааг сайжруулах талаар судалгаанд оролцогчдын гаргасан тусгайлсан санал:

- Хууль, дүрэм, журмыг сайжруулах, хөдөлмөрийн аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллах, Мэдээллийн технологийн дэвшлийг бүрэн ашиглах
- Нээлттэйгээр хийсэн ажлаа ирээд олон нийтэд тайлагнах сурталчилгааг тогтмол явуулж байх
- 1. хариуцлагатай уул уурхай 2. байгаль орчныг хамгаалах (ААН-үүд) 3. УУЯАмны мэргэжилтнүүдэд байгаль орчны мэдлэг өгөх 4. хүний нүдэнд харагдах ажлууд хийх
- Нөхөн сэргээлтийн асуудал дээр анхаарал хандуулах
- Мэдээлэл ил тод, үйл ажиллагаа шударга байдлыг хангах
- Холбогдох бусад түмийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, төрийн байгууллагуудын нэгдсэн бодлого төлөвлөлттэй байх, мэргэжлийн боловсон хүчний мэдлэг чадвар дээшлүүлэх, тогтвортой байдлыг хангах
- Томоохон төслүүдийг хөдөлгөх. Баялгийн сан байгуулах. Оюу толгойгоос гарч буй баялгийг зөв зарцуулах
- Арын хаалгаар мөнгө төлж ажилд орсон ашиг сонирхлын зөрчилтэй хүмүүсийн оронд мэргэжлийн зөв шударга хүмүүсийг ажиллуулах
- Зохион байгуулалт сайжруулах
- Боловсон хүчин сайжруулах
- Уул уурхай буюу ухах ашиглах томъёоллоос салаад ашиглах борлуулах ашиг олох хэлбэрт шилжих цаг болсон
- Бодлогын шинжилгээг хийж, бодлого шинжилдэг байх хэрэгтэй энэ ажил ердөө ч хийгддэггүй
- Мэргэжлийн мэргэшсэн удирдлага- төрийн тогтвортой бодлого хэрэгжүүлэх
- Мэргэжилтэн ажилчдаа чадваржуулах - судалгаанд үндэслэн шийдвэр гаргах
- Мэргэжлийн чадвартай боловсон хүчнээ дэмжин ажиллуулах-сайд удирдлага нь тогтвортой ажилламаар байна
- Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжиж ажиллах, геологи уул уурхай баяжуулалтын салбарыг дэмжих төсөл хэрэгжүүлэх ажлыг дэмжих, УУХҮЯ санаачлагач байх, төсвийн хөрөнгөөр хийлгэж байгаа геологийн ажлын 20%-ийг улсын байгууллага хийлгүүлж байх

- Бүтэц тогтвортой биш болохоор уул уурхай хүнд үйлдвэрлэлийн талаар томоохон бодлого боловсруулалт учир дутмаг гэж боддог
- Статистикийн мэдээлэл ил тод хангалттай хэмжээнд байх
- Хэт нүсэр бүтэцгүй хүнд сурталгүй шуурхай байх
- Аймаг сумдын засаг дарга нарыг хяналтад байлгах тэгж байж ул уурхайг дагнасан дэд бүтэц хөгжинө
- Бие даасан геологийн байгууллага шаардлагатай байна. Хавсралт байх ёсгүй. Геологи нь зөвхөн ашигт малтмалтай хамаатай биш. Маш олон экологийн асуудлыг авч үзэх хэрэгтэй. Олон түмэн ард иргэдэд чиглэсэн геологийн боловсролын хөгжүүлэх талаар багц хууль боловсруулахдаа оруулах шаардлагатай байна.
- Төрийн албан хаагчдын мэргэжлийн түвшнийг нэмэгдүүлэх ил тод байдлыг сайжруулах
- Геологийн судалгааг эрчимжүүлэх
- Геологичдын бүтээлч судалгаа хийх санаачилгыг нь бүрэн үгүй хийж байгаа 1005 хайгуулын тусгай зөвшөөрлөөр олгодог болсныг эргэн харах хэрэгтэй байна
- Бичил уурхайчин, хөөргөөд байдаг нинжа нарт зориулж хууль журам гарган өгөхөө болих
- Геологийн чиглэлд мэргэшүүлэх туршлага салбарын чиглэлд ажилласан туршлагатай байх


ТАВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Хүснэгт. 5.1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үйл ажиллагаануудад хэрэглэгчээс өгсөн үнэлгээ

Бүлгүүд	Үзүүлэлтүүд	Ач холбогдолгүй	Бага	Дунд	Их	Маш их	Мэдэхгүй
II. САЛБАРЫН МЭДЭЭЛЛИЙН ХҮРТЭЭМЖ, ИЛ ТОД БАЙДАЛ	Та уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны хэрэгжүүлж байгаа ажлууд болон ил тод байдлыг хэрхэн үнэлж байна вэ?	5.8%	26.2%	32.0%	13.5%	7.3%	15.3%
	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны худалдан авах үйл ажиллагаа буюу тендер шалгаруулалтыг хэр шударга явагддаг гэж үздэг вэ?	9.5%	25.8%	21.5%	10.5%	5.1%	27.6%
	Та уул уурхай, ашигт малтмалын талаар мэдээлэл авахдаа ямар эх сурвалж ашигладаг вэ?	6.5%	18.5%	29.0%	16.1%	10.5%	19.4%
III. САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ	Эрдэс баялгийн салбарт төрөөс баримталж буй бодлогын баримт бичгүүд ард иргэдэд хэрхэн хүрч байгаа гэж Та бодож байна вэ?	11.4%	43.4%	21.4%	6.8%	6.0%	11.0%
	“Ашигт малтмалын тухай” хуулийн нэмэлт өөрчлөлтөд Та хэр сэтгэл ханамжтай байгаа вэ?	10.5%	25.0%	21.7%	12.7%	7.2%	22.8%
	Салбарын хуулийн хэрэгжилтийг хангуулах, эрх зүйн орчныг сайжруулахын тулд Газрын хэвлийн багц хууль боловсруулах, өөрчлөлт хийх саналыг Та дэмжиж байна уу?	11.1%	14.0%	9.6%	19.2%	25.5%	20.7%
IV. САЛБАРЫН БОДЛОГО, ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ХЭРЭГЖ	Хүнд үйлдвэрийн талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичиг нь салбарын хөгжлийн төлөв, улс орны эдийн засаг, нийгмийн хөгжилд оруулах үүрэг оролцоог бүрэн тодорхойлсон гэж үзэж байна уу?	9.6%	24.3%	21.7%	11.4%	9.2%	23.9%
	Ашигт малтмал газрын тосны газар орон нутаг руу чиглэсэн үйл ажиллагааг Та хэрхэн үнэлэх вэ?	9.6%	33.8%	19.9%	12.9%	8.5%	15.4%

ИЛТ, ҮНЭЛГЭ Э	Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлын төлөвт, үйл ажиллагааны явцыг Та хэрхэн үнэлж байна вэ?	7.7%	28.8%	24.8%	13.9%	7.3%	17.5%
	Газрын тосны геологийн судалгааны ажлын төлөвлөлт, ажлын үр дүн, үйл ажиллагааг Та хэрхэн үнэлэх вэ?	9.5%	27.3%	25.1%	11.6%	6.5%	20.0%
	Хувийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлын төлөвлөлт, ажлын үр дүн, үйл ажиллагааг Та хэрхэн үнэлэх вэ?	6.7%	18.5%	20.0%	23.0%	12.6%	19.3%
	Газрын тос, байгалийн хий, шатдаг занар, нүүрс зэрэг ус төрөгчдийн нэгдлийн ашигт малтмалын геологийн судалгааны ажлыг Та хэрхэн үнэлэх вэ?	8.1%	22.3%	24.9%	12.8%	7.3%	24.5%
	Төрөл бүрийн ашигт малтмалын олборлох, баяжуулан боловсруулах үйлдвэрийн талаарх стратегийн төлөвлөлт, хүрсэн үр дүнг Та хэрхэн үнэлэх вэ?	6.9%	27.5%	27.2%	8.7%	8.7%	21.0%
	Улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд уул уурхайн салбарын үзүүлж буй ач холбогдлыг Та хэрхэн үнэлэх вэ?	5.8%	17.8%	19.6%	23.6%	22.8%	10.5%
	Уул уурхайн нөхөн сэргээлтийн ажлын түвшинг Та хэрхэн үнэлэх вэ?	16.2%	38.3%	20.6%	10.5%	5.8%	8.7%
	Уул уурхайн салбарын үйл ажиллагааны үр дүнд ажлын байр нэмэгдсэн.Энэ нэмэгдэл нь хангалттай хэмжээнд байж чадаж байна уу?	6.0%	26.7%	34.9%	15.3%	5.7%	11.4%
	Уул уурхайн компаниудын хөдөө, орон нутаг дахь хөрөнгө оруулалтыг Та хэрхэн үнэлэх вэ?	8.4%	32.7%	23.6%	14.5%	9.1%	11.6%
	Дундаж үнэлгээ	8.8%	26.5%	23.4%	13.9%	9.7%	17.7%

График.5.1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үйл ажиллагаануудад хэрэглэгчээс өгсөн үнэлгээний дундаж (Ерөнхий үнэлгээ)



Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үйл ажиллагааг мэдээллийн хүртээмж, ил тод байдал, эрх зүйн орчны үнэлгээ, бодлого хөтөлбөрүүдийн хэрэгжилт үнэлгээ гэсэн үндсэн 3 бүлэгт 17 үзүүлэлтээр задалж хэрэглэгчдээс үнэлүүлэв. Дээрх 17 үзүүлэлтийн үнэлгээний дундаж тооцож үзвэл: **Хэрэглэгчд УУХҮЯ-ны үйл ажиллагаа нийт үйл ажиллагааг 8.8 хувь нь ач холбогдолгүй, 26.5 хувь бага, 23.4 хувь нь дунд, 13.9 хувь нь сайн, 9.7 хувь нь маш сайн гэж тус тус үнэлсэн бол 17.7 хувь нь үнэлж хараахан мэдэхгүй байгаагаа илэрхийлжээ.**

Хүснэгт 5.2. Ерөнхий үнэлгээ

Бүлгүүд	Үзүүлэлтүүд	5 оноо	Дундаж оноо	Үгээр	100%
II. САЛБАРЫ Н МЭДЭЭЛЛ ИЙН ХҮРТЭЭМ Ж, ИЛ ТОД БАЙДАЛ	Та уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны хэрэгжүүлж байгаа ажлууд болон ил тод байдлыг хэрхэн үнэлж байна вэ?	3.02	3.06	Дунд	70%
	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны худалдан авах үйл ажиллагаа буюу тендер шалгаруулалтыг хэр шударга явагддаг гэж үздэг вэ?	2.9			
	Та уул уурхай, ашигт малтмалын талаар мэдээлэл авахдаа ямар эх сурвалж ашигладаг вэ?	3.25			
III. САЛБАРЫ Н ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ	Эрдэс баялгийн салбарт төрөөс баримталж буй бодлогын баримт бичгүүд ард иргэдэд хэрхэн хүрч байгаа гэж Та бодож байна вэ?	2.6	3.17	Дунд аас дээгү үр	73%
	„Ашигт малтмалын тухай” хуулийн нэмэлт өөрчлөлтөд Та хэр сэтгэл ханамжтай байгаа вэ?	3.03			
	Салбарын хуулийн хэрэгжилтийг хангуулах, эрх зүйн орчныг сайжруулахын тулд Газрын хэвлийн багц хууль боловсруулах, өөрчлөлт хийх саналыг Та дэмжиж байна уу?	3.8			
IV. САЛБАРЫ Н БОДЛОГО , ХӨТӨЛБӨ РҮҮДИЙН ХЭРЭГЖИ ЛТ, ҮНЭЛГЭЭ	Хүнд үйлдвэрийн талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичиг нь салбарын хөгжлийн төлөв, улс орны эдийн засаг, нийгмийн хөгжилд оруулах үүрэг оролцоог бүрэн тодорхойлсон гэж үзэж байна уу?	3.08	3.07	Дунд	70%
	Ашигт малтмал газрын тосны газар орон нутагруу чиглэсэн үйл ажиллагааг Та хэрхэн үнэлэх вэ?	2.9			
	Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлын төлөвт, үйл ажиллагааны явцыг Та хэрхэн үнэлж байна вэ?	2.9			
	Газрын тосны геологийн судалгааны ажлын төлөвлөлт, ажлын үр дүн, үйл ажиллагааг Та хэрхэн үнэлэх вэ?	2.9			
	Хувийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлын төлөвлөлт, ажлын үр дүн, үйл ажиллагааг Та хэрхэн үнэлэх вэ?	3.4			
	Газрын тос, байгалийн хий, шатдаг занар, нүүрс зэрэг ус төрөгчдийн нэгдлийн ашигт малтмалын геологийн судалгааны ажлыг Та хэрхэн үнэлэх вэ?	3.07			
	Төрөл бүрийн ашигт малтмалын олборлох, баяжуулан боловсруулах үйлдвэрийн талаарх стратегийн төлөвлөлт, хүрсэн үр дүнг Та хэрхэн үнэлэх вэ?	2.9			
	Улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд уул уурхайн салбарын үзүүлж буй ач холбогдлыг Та хэрхэн үнэлэх вэ?	3.6			
	Уул уурхайн нөхөн сэргээлтийн ажлын түвшнийг Та хэрхэн үнэлэх вэ?	2.7			
	Уул уурхайн салбарын үйл ажиллагааны үр дүнд ажлын байр нэмэгдсэн.Энэ нэмэгдэл нь хангалттай хэмжээнд байж чадаж байна уу?	3			
	Уул уурхайн компаниудын хөдөө, орон нутаг дахь хөрөнгө оруулалтыг Та хэрхэн үнэлэх вэ?	3			
	Ерөнхий үнэлгээ	3.1			
		3.1		Дунд	71%

“Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай” хуулийн 20.1 дэх заалт, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан **“Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”**, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/122 дугаар тушаалаар батлагдсан, “Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг үнэлэх журам”-ыг тус тус үндэслэн яамны үйл ажиллагаанд Хэрэглэгчийн үнэлгээг хийлгэх ажлыг зохион байгуулав.

Хэрэглэгчийн үнэлгээг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны 302 дугаар тушаалаар батлагдсан, “Хэрэглэгчийн үнэлгээний ерөнхий удирдамж”-ийн хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар иргэдээс санал асуулга авах нарийвчилсан удирдамж, ажлын даалгавар, түүвэр судалгаа авах асуулгыг тус тус боловсруулж хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлэв.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үйл ажиллагаанд хийсэн хэрэглэгчийн үнэлгээний түүвэр судалгаанд төрийн байгууллагад ажилладаг 162, салбарын хувийн хэвшилд ажилладаг 342, их, дээд сургуульд ажилладаг 72, нийт 576 хүн хамрагдсан байна.

№	Утга	Тоололт	Хувь
1	Төрийн байгууллага	162	28.1
2	Хувийн хэвшил	342	59.4
3	Их, дээд сургууль	72	12.5
Нийт		576	100

Судалгаанд оролцогчдын насны бүтцийг харвал 10 хувь нь 24 хүртэлх насныхан, 40 хувь нь 25-34 насныхан, 33 хувь нь 35-44 насныхан, 10 хувь нь 45-54 насныхан, 7 хувь нь 55-аас дээш настай иргэд байна. Тэдний 64 хувь нь эрэгтэй, 36 хувь нь эмэгтэйчүүд байсан, 90 хувь нь дээд боловсролтой, үлдсэн 10 хувь нь суурь, бүрэн дунд болон техникийн болон тусгай мэргэжлийн боловсрол эзэмшсэн хүмүүс хамрагджээ

Судалгаанд оролцогчдын 35 хувь нь төрийн байгууллагад, 53 хувь нь хувийн байгууллагад, 5 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 4 хувь нь төрийн бус байгууллагад, 3 хувь нь олон улсын байгууллагад тус тус ажилладаг байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үйл ажиллагааг мэдээллийн хүртээмж, ил тод байдал, эрх зүйн орчны үнэлгээ, бодлого хөтөлбөрүүдийн хэрэгжилт үнэлгээ гэсэн үндсэн 3 бүлэгт 17 асуулгаар түүвэр судалгааг хийлгэв.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд хэрэглэгчийн өгсөн үнэлгээгээр ерөнхий дүн 71,0 %-тай байна.

Ашигласан материал:

1. Ханнс-Зайделийн сан, “Эрх зүйн боловсрол” академи. МУ-ын Үндсэн хуулийн тайлбар. 2009 он, УБ хот.
2. GTZ /хуульчдын сургалт ба давтан сургалт төсөл/, ХЗДХЯ, ХЗҮТ. МУ-ын Иргэний хуулийн тайлбар (ерөнхий анги). 2006 он, УБ хот.
3. С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. 2008 он, УБ хот.
4. Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэн, Хүний эрхийн боловсролын төв. Хууль зүйн тайлбар толь. 2003 он, УБ хот.
5. УИХТГ-Судалгаа, шинжилгээ, олон нийттэй харилцах төв. Бодлогын судалгаа, шинжилгээ (судалгааны эмхэтгэл). 2009 он, УБ хот.
6. Ашигт малтмалын газар. Ашигт малтмал-Эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл. 2009 он, УБ хот.
7. МӨХ, Сургалтын дэд хороо. Ашигт малтмалын тухай хуулийг хэрэглэж буй шүүхийн практик. 2010 он, УБ хот.
8. Монгол улсын Үндэсний Аудитын Газар. Улсын Их Хурлын саналын дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан. 2007 он, УБ хот.
9. ЗГХФ уул уурхайн бодлогын үзэл баримтлалын үнэлгээ, 2017 оны 4 сар
10. Хууль тогтоомжийн тухай хууль /аргачлал, гарын авлага/
11. Иргэдийн оролцооны эрх зүйн орчин ба үнэлгээ судалгааны тайлан., Улс төрийн боловсролын академи, 2013 он.,УБ хот

Веб сайт:

1. Legalinfo.mn
2. Forum.mn
3. <http://www.eiti.mn/index.php?pid=5>
4. <http://www.geos.mn/index.php?lang=mn>
5. <http://www.dailynews.mn/?vfile=9tpui7&lid=241>
6. <http://www.meforum.mn/index.php?action=>
7. <http://www.mongolianminingjournal.com/index.php?pid=1>
8. <http://www.uiowa.edu/ifdebook/index.shtml>